



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/518

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сумын цэцэгжүүлэлтийн ажлыг хийсэн “Урд, хойд, дунд гурван дүмбүү” хоршоо, “Аргалант мөнхөд ногоон” ХХК, “Буянт үр жимс инженеринг нэгдэл” ХХК-нуудын ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Ц.Цогтбаяр	- Жаргалант сумын Засаг дарга
Гишүүд:	Б.Пүрэвдорж	- Хот тохижилтын газрын дарга
	Б.Баяржавхлан	- Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны улсын байцаагч
	Б.Золбаяр	- Хот тохижуулах газрын дендорлогич
	Б.Түмэнжаргал	- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
	Л.Нямдорж	- “Урд, хойд, дунд гурван дүмбүү” хоршооны дарга
	Г.Мишка	- “Аргалант мөнхөд ногоон” ХХК-ийн захирал
	Н.Эрдэнэбаяр	- “Буянт үр жимс инженеринг нэгдэл” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга:	Ц.Пүрэвсүрэн	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Цэцэгжүүлэлтийн ажлыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Ц.Цогтбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН